**2019.07.16-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШУУРХАЙ ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2019.07.08 №20 Дархан

| № | Өгөгдсөн үүрэг даалгавар | Хариуцах эзэн | Хэрэгжилт |
|---|---|---|---|
| 1 | Ихэнх дарга нар ээлжийн амралтаа авсан байна. Орлож байгаа хүмүүсийг тодорхой болгох | /ТЗУХ/ | 2019 оны 3 сарын 11-ний өдрийн 2-Б/17 дугаар тушаалаар аймгийн ЗДТГ-ын дарга, мэргэжилтнүүдийн ээлжийн амралтын хуваарийг баталсан. Удирдлага, хэлтсийн дарга нараас ээлжийн амралтаа аваагүй дараах хүмүүс байна.<br>Т.Ганболд<br>П.Баярсайхан<br>П.Батсүх<br>Н.Цасчихэр<br>Б.Болдбаатар<br>Б.Золзаяа<br>Одоо амарч байгаа болон амралтаа авсан:<br>А.Түвшинбат<br>Ч.Энхбат<br>Л.Алтанчимэг<br>Б.Жаргалсайхан<br>Д.Жаргалсайхан |
| 2 | Маргааш Тэргүүлэгчдийн хуралтай тул бэлтгэлийг хангах | /ТЗУХ/ | 2019 оны 7 дугаар сарын 17-ны өдөр 09.00 цагт аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурал зохион байгуулагдсан. Батлагдсан хөтөлбөрийн дагуу 3 асуудлыг нягталж оруулсан. |
| 3 | Өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гарсан байх ёстой. Яамнаас албан даалгавар ирсэн үү? Тодруулаарай. | /ЗА/ | Төрийн байгууллагуудаас өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө авч нэгтгэсэн. 2019-2020 оны өвөлжилтийг даван туулах ажлын төлөвлөгөөний төсөл бэлэн болсон. |
| 4 | Замын компани өнөөдөр ирэх байх. Хустай хүртэл 1000 гаран мал тоолсон. Энийг яах вэ? | /ЗА/ | Хонгор сумын ЗДТГ-т албан бичгээр хандаж мал бүхий айл өрхүүдийг нүүлгэх шилжүүлэхийг мэдэгдсэн. |
| 5 | Зарлаагүй тендерийн талаар мэдээллийг надад өгөөрэй. Би маргааш Батсүх, Батсайхантай явж хөрөнгө оруулалтын ажлуудыг үзнэ. | /ХОХБТХ/ | 1.100 сая төгрөгийн төсөвт өртөгтэй мөсөн гулгуурын талбай<br>2. 30 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 дүгээр багийн авто зогсоолын ажлуудын тендер зарлагдаагүй байна. |
| 6 | Постоо буулгая. Яамтай ярьж постоо буулгах талаар яриарай. Шороон замаар явж явж очдог. Мөнгө нэхдэг. Ард иргэд маш их бухимдаж байна. Яамтай нь яриад постыг нь буулгуулах шаардлагатай байна.<br>Энэ 7 хоногт багтааж Шунхлайгийн колонкийг буулгая. Ус сувгийн шугам бас байгаа. | /ЗА/ | Дархан УБ авто замын трасст орсон Дархан ус сувагийн шугамыг зөөж байрлуулах зураг төсвийг экспедицээр оруулж батлуулсан. Зам тээврийн яамтай гэрээ байгуулж ажиллахаар болсон. Шугамын зөөж байруулахад 150,0 сая төгрөгний зардлын тооцоо гарсан урьдчилгаа 30% хөрөнгө |

| | | | |
|---|---|---|---|
| | | | шийдэгдвэл ажлыг эхлүүлэхээр төлөвлөж байна. Сангийн яаманд нэхэмжлэх явуулсан. |
| 7 | 16 дугаар сургуулийн талбайн зураг төсвийг Дархан сум хийсэн байна. Дархан сум зургаа Батсүх даргад өгөөрэй. Батсүх үзээд танилцуулаарай. | /Дархан сум, ХОХБТХ/ | 16 дугаар сургуулийн талбайн зураг төсвийг Ерөнхий эдийн засагч Б.Батсүхэд Дархан сумаас өгсөн. Хэлтсийн даргад танилцуулахаар бэлтгэж байна. |
| 8 | Жижиг дундын захирамж гарсан байх ёстой. Банкинд очоогүй байна. Яаралтай хүргүүлэх шаардлагатай байна. | /СТСХ, ХОХБТХ/ | Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн захирамж гараагүй байгаа бөгөөд захирамжийн төсөл нь Засаг даргаар хянагдаж байгаа болно. Захирамж гарсны дараа Дархан сум банкуудтай гэрээ хийсний дараа зээл олгогдоно гэсэн мэдээллийг ХХААГ-ын мэргэжилтэнгээс тодруулаа. |
| 9 | Архивын үзлэг удахгүй эхэллээ. Алтанчимэг дарга амарсан. Архивын дарга нь амарсан. Анхааараарай. Хууль зүйн сайдад хүсэлт тавьж байгаад хойшлуулсан. Алтанчимэгийг орлож байгаа хүн нь хэн юм? Энхсайхан хаана байгаа юм? Энэ асуудлыг эзэнжүүлээрэй. Амарч орч ирээд л улсын үзлэг шүү. | /ХЭЗХ/ | Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч Н.Баярбаатарт ажлын хэсгийн дарга бөгөөд аймгийн Засаг даргын орлогчтой уулзаж Архивын үзлэгт бэлтгэх чиглэлээр хийж буй ажлын явцыг танилцуулах, Үзлэгт бэлтгэх ажлын хэсгээс төрийн байгууллагуудад хийж буй үзлэгийн явц, үндсэн ажлын хэсгийн шалгалтын явцыг танилцуулах үүрэг өгсөн. Н.Баярбаатараас аймгийн Засаг даргын орлогчтой уулзаж үзлэгийн үндсэн ажлын хэсгээс хийж буй шалгалтыг дуусгах дутуу байгаа 14 байгууллагаар явах зэрэг ажлыг ярьж тохиролцсон болно. |
| 10 | Дархан орон нутгийн зам, тээвэр ОНӨААТҮГ-д хяналтын хороо очиж ажилласан. Аймгаас ажлын хэсэг гараад явж үзсэн. Ажилласан протоколыг нь олж үзмээр байна. Үргэлжлүүлэх юм уу? Яах юм? Хурдан шийдэх хэрэгтэй байна. | /ХОХБТХ/ | Аймгийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн “Байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үнэлж дүгнэх, зөвлөн туслах ажлын удирдамж”-ийн дагуу ажлын хэсэг хяналт шалгалтыг хийж 2019 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ажлын хэсгийн тайлангаа гаргаж аймгийн Засаг даргад танилцуулсан. |
| 11 | Дахин төлөвлөлтийн шинэ байрны ус юу болсон бэ? Өртэй айлуудын усыг хаасан байсан. Наадмаар юу болсон бол? | /ЗА/ | Дахин төлөвлөлтийн 710 дугаар байрны оршин суугчдын цэвэр усаар хангасан. Төлбөрийн тооцоотой 2 айлын усыг Дархан Ус суваг ХК-аас хаасан байгаа. |
| 12 | “Шарилжгүй Дархан” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд багийн оролцоо муу байна. Багууд нутаг дэвсгэр дээрээ байгаа аж ахуйн нэгжүүдээ үүрэгжүүлээд биелэлтийг нь тооцоод аваарай. | /Дархан сум/ | Багийн Засаг дарга нарын хурал дээр чиглэл өгсөн. |
| 13 | Мэдээ тайлангууд цагтаа явж | /ТЗУХ, | ХШҮДАХ-ээс хариуцан ЗГ-ын |

| | | | |
|---|---|---|---|
| | байгаа юу? | ХШҮДАХ/ | хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд хэрэгжилт, танилцуулга, хурлын тэмдэглэлийг оруулж, баталгаажуулах 3 баримт бичгийн хэрэгжилт хугацаандаа (2019.07.01-ний өдөр багтаж) баталгаажиж, цаасан хэлбэрээр ЗГХЭГ-т хүргэгдсэн. Үүнд:<br>1. Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний танилцуулга, ЗДЗХ-ын тэмдэглэл-2019.06.28-ны өдрийн 1-10/457 тоот албан бичгээр хүргэгдсэн. Цахим санд баталгаажсан байдал:<br><br><br>2. ЗГҮАХ-ийн хэрэгжилт, хэрэгжилтэд хийсэн ХШҮ-ний танилцуулга, ЗДЗХ-ын тэмдэглэл-2019.06.28-ны 1-10/438 тоот албан бичгээр хүргэгдсэн. Цахим санд баталгаажсан байдал:<br><br><br>3. Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ-2019.07.01-ний өдрийн 1-10/460 тоот албан бичгээр хүргэгдсэн. Цахим санд баталгаажсан байдал:<br><br> |
| **14** | Нийгмийн хөгжлийн төлөвлөгөөний сургалтын талаар мэдээлэл хэрэгтэй байна.17,18-ны өдрүүдэд манайх болон Дархан | /ХОХБТХ, МТА, Дархан | Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төслийн хүрээнд "Нийгмийн хөгжлийн төлөвлөгөө"-г танилцуулж |

| | | | |
|---|---|---|---|
| | сумын хурлын зааланд хийнэ гээд МТА-д би хэлж бичүүлсэн байх ёстой. 50 хүний сургалт төслөөс зохион байгуулах юм билээ. 98112460 утсаар холбогдоод надад мэдээлэл өгөөрэй. | сум/ | оролцогч талуудад мэдээлэл олгох, нэмэлт санал авах зорилготой сургалтыг зохион байгуулах тус төслийн Нийгмийн хөгжлийн ажилтан Б.Сувд-Эрдэнэ 2019 оны 07 дугаар сарын 17-ны өдөр Дархан-Уул аймагт ирсэн. Мэдээлэл технологийн албаны мэргэжилтэн Уганцэцэгтэй уулзаж холбогдох мэдээлэл авсан. Ихэнх ажилтан албан хаагчдийн амралтын цаг хугацаа таарч байгаа тул сургалтаа хойшлуулахаар шийдвэрлэж , дахин холбогдож хугацаагаа мэдээлэхээр болсон. |
| **15** | Наадмын тайланг түргэн авах шаардлагатай байна. Өнгөрсөн жил асуудал үүссэн шүү. Явсаар байгаад намар болоод өр нь нэхэгдээд колонкууд нь шатахуун өгөөгүй. Худалдаа, үйлчилгээний ажлын хэсэг 3 сая төгрөг орлого тасалдуулсан. Одоо комиссуудаас нь тайлангаа аваарай. Энэ жил бас л орлого тасалдсан гэсэн юм яриад байна лээ шүү. Станцын Чимэддорж захирлаас мөнгө гаргуулаад морины шагнал өгсөн байгаа. Эртхэн тайлангаа гаргаад хүмүүст мөнгийг нь буцааж олгоорой. | /СТСХ/ | 2019 оны 01-А/219 дугаар захирамжаар баяр наадмын тусгай зөвшөөрлийн орлогыг 21.5 сая төгрөгөөр баталснаас Худалдаа үйлчилгээний ажлын хэсэг, Хэв журмын ажлын хэсгүүд нийт 21.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. АЗДТГ-ын нягтлан бодогч ажлын хэсгүүдээс тайлангуудыг нэгтгэж байна. 21.5 сая төгрөгийн төсөвтэй холбоотой морин уралдааны салбар хороо, тохижилт реклам чимэглэлийн ажлын хэсгүүдийн гүйцэтгэл гараагүй байна. |
| **16** | Маргааш 14.00 цагаас цахим хуралтай. Оролцоог хангуулах | /ТЗУХ/ | Монгол Улсын үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн Төслийг иргэдэд танилцуулах үүрэг бүхий "Сургагч багш" бэлтгэх онлайн сургалтад хамрагдах албан тушаалтнуудын нэрсийг гаргаж Улсын Их Хурлын Тамгын газарт 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 03-10/971 тоот албан бичгээр 11 албан хаагч хамрагдах тухай хариу хүргүүлсэн. Уг сургалтанд манай аймгаас 11 албан тушаалтан суухаас 10 албан тушаалтан сууж сургалтын ирц 90.9 хувь байлаа. |

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА П.БАЯРСАЙХАН

НЭГТГЭСЭН:ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН: Ц.БОЛОРТУУЛ